**Тєвийн эрхэм зорилго**
Дэлхийн болон бvс нутаг, улс орны аюулгvй байдлын орчны толов, хогжлийн хандлагад судалгаа явуулах.



**Үйл ажиллагааны зорилго:**
Дэлхийн болон бvс нутгийн аюулгvй байдлын орчны толов, хогжлийн хандлага болон батлан хамгаалах тогтолцоо, бодлого, vйл ажиллагааны vндсэн чиглэлийн хvрээнд судалгаа явуулж, шинжлэх ухааны vндэслэлтэй санал, зовломж боловсруулахад оршино.

**Үйл ажиллагааны гол зорилт:**

- Аюул занал, олон улсын болон бvс нутгийн аюулгvй байдлын тогтолцоо, хувьсал оорчлолтод задлан шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагад судалгаа явуулах;
- Хорш орнууд болон Орно, Дорны нолоо бvхий улс орнуудаас Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгvй байдлын талаар баримталж байгаа бодлого, тэдгээртэй тогтоосон цэргийн харилцаа, хамтын ажиллагаанд дvн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлаар цаг vеэ олсон мэдээлэл боловсруулах;
- Батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны тулгуур vндэс болох орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бvрдvvлэх, дайчилгааны тогтолцоог бэхжvvлэх асуудлаар суурь болон хэрэглээний судалгаа явуулах;
- Батлан хамгаалах бодлогын улс тор, эдийн засаг, нийгэм, эрх зvйн чиглэлээр судалгаа явуулах.

**Тvvхэн замнал**

Социалист хамтын нохорлолийн орнуудын батлан хамгаалах нэгдсэн тогтолцоо задарсан 1990-ээд оны эхэн vеэс манай улс эх орноо батлан хамгаалах асуудалд бие даасан байр сууринаас хандах зайлшгvй шаардлагатай тулгарч, батлан хамгаалах бодлогоо шинээр боловсруулах, тvvний эрх зvйн орчин, нэгдмэл тогтолцоог бvрдvvлэх ажилд шуурхайлан орсон билээ. Энэхvv тvvхэн vйл явцын шинжлэх ухааны vндэслэлийг хангахад дэмжлэг vзvvлэх зорилгоор тус тов нь анх 1999 онд БХЯ-ны торийн нарийн бичгийн даргын тушаалаар Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэнгийн орон тоо, зохион байгуулалтын бvтцэд **БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ** болж, 1997 оны 11 дvгээр сарын 1-ээс эхлэн ажиллаж байсан Зэвсэгт хvчний байгуулалтын судалгааны товийн суурин дээр байгуулагдсан.

Тус товийн анхны даргаар хурандаа С.Уламбадрах, эрдэм шинжилгээний ажилтнаар хошууч генерал Р.Гаваа, хурандаа Б.Цэрэнчимэд, ахлах дэслэгч Ч.Болдбаатар нар ажиллаж байсан юм.

Батлан хамгаалахын сайдын 2016 оны 06 дугаар сарын 14-ний одрийн А/177 дугаар тушаалаар “**Аюулгvй байдал, батлан хамгаалах судлалын төв**” нэртэйгээр vйл ажиллагаагаа явуулж байна.